



Аудитын код: САГ-2017/27/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261628 Цахим хаяг: gungidmaag@audit.gov.mn

Аудитор Ц.Цэрэнхүү

Утас: 261885 Цахим хаяг: tserenkuu_@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1 Оршил	4
2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	4
2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорил, түүний үр дүн	6
2.5 Дотоод хяналт	6
2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	7
2.7 Шилэн дансны мэдээлэл	7
2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	8
2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	10
2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	10
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар: Error! Bookmark not defined.	
2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3. Менежментийн захидал.....	12
3.1 Зардал.....	13
3.2 Авлага.....	14
3.3 Цалин.....	15
3.4 Төсвийн орлого	16
3.5 Худалдан авалт	17
3.6 Дотоод хяналт	18
Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	19
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	19
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	20
4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	21
4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	22
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	24

1. Аудитын гэрчилгээ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.04.25 № 761
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг БСШУС-ын сайд Ж.Батсуурь танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай салбарын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 10-наас 2017 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Ц.Цэрэнхүү хариуцаж хэрэгжүүлэв.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 1А/2399 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын яамны эрхэм зорилго нь хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэн иргэн бүрийг өрсөлдөх чадвар бүхий "Зөв монгол хүн" болгон төлөвшүүлэх боловсролын олон талт нөхцөл, боломжийг бүрдүүлэх, үндэсний болон дэлхийн өв, соёлд суурилсан, үндэсний онцлог бүхий соёл, урлагийн салбарыг хөгжүүлэх, шинжлэх ухаан, инноваци, өндөр технологийн үр өгөөжийг сайжруулж эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд оршино гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.8-д “Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагчийн үүрэг гүйцэтгэнэ” гэж заасны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд дээрх үүргийг гүйцэтгэж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны төсвийг Сангийн яамны Төрийн сангаас олгосон байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны үйл ажиллагааны талаар (ТАБ-СТА-А-1) маягтад тодорхой тусгасан.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны удирдлага нь Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.(ТАБ-СТА-А-5)

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсвийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, БСШУС-ын сайдын 2017 оны А/40 дугаар тушаалаар мөрдөн ажиллаж байгаа ба энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС, нягтлан бодох бүртгэлийн програмтай нийцсэн байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “Е-тайлан” програмаар боловсруулан Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргасан байна.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 10 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Энэ нь материаллаг алдаа гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт “дунд” байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03 дугаар тогтоолоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны бүтцэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар байхаар заасны дагуу 1 дарга, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлийн 3 мэргэжилтэн, санхүүгийн дотоод аудитын 2 мэргэжилтэн гэсэн орон тоотой ажиллаж байна. Тус яамны ХШҮДАГ нь үйл ажиллагаандаа БСШУ-ны сайдын /хуучин нэрээр/ 2013 оны А/201 тушаалаар батлагдсан “Боловсрол, шинжлэх ухааны яам болон түүний харьяа байгууллагад дотоод аудитын үйл ажиллагаа явуулах журам”-ыг мөрдөн ажиллаж байна.

Дотоод аудитын болон санхүүгийн хяналт шалгалт хийх жилийн төлөвлөгөөг ТЕЗ-аар батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шинжлэх ухаан, соёл, урлагийн салбарын нэр бүхий 10 байгууллагад санхүүгийн дотоод аудитын шалгалт хийж, 435.1 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлсэн байна.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг яамны Төрийн нарийн бичгийн даргаар хянуулж, батлагдсан төсвийн хүрээнд Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжигдсэн ба төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлийг нь хянаж ажилласан байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар улсын төсвөөс урсгал зардалд 1,042,048.4 сая төгрөгийн, хөрөнгө оруулалтын зардалд 180,188.4 сая төгрөгийн, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд 31,063.5 сая төгрөгийн, нийт 1,253,300.3 сая төгрөгийн эх үүсвэртэй тайлагнагдсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 1,338,660.5 сая төгрөгийн төсөв батлагдаж, 1,253,300.3 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 85.360.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу байршуулсан байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудас дахь шилэн дансны цэс нь төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт, бусад, Сангийн яамны мэдээлэл гэсэн дөрвөн дэд цэстэй бөгөөд эдгээрийг бүлэглэсний дагуу 300 гаруй мэдээлэл байршуулсны гадна Төсвийн ерөнхийлөн захирагчийн шууд харьяалагддаг 58 байгууллагуудын өөр өөрийн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг 2016 оны байдлаар 7662 мэдээллийг байршуулахаас 7564 мэдээлэл байршуулж, 99.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх төлөвлөгөөгөөр төлөвлөлтийн шатанд 4 дансанд эрсдэл байж болзошгүй гэж тогтоосны дагуу нарийвчилсан сорилын аргаар тулган баталгаажуулах, ажиглах, харьцуулах зэрэг сорилыг гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үе шатыг 11, гүйцэтгэлийн үе шатыг 9, тайлагналын үе шатыг 7 ажилбараар гүйцэтгэж, аудитын менежер, газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор хянав.

Мөн үйлчлүүлэгчээс авсан судалгаа, тоон мэдээлэл, тайлбар, нотлох баримтуудыг ажлын баримтаар хадгалав.

Дээрх горим, сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд 2 төсвийн төвлөрүүлэн захирагч, 104 төсвийн шууд захирагчийн тайлан нэгтгэгдсэн байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудын 77 байгууллага буюу 72.6 хувь нь “Зөрчилгүй” санал дүгнэлт, 9 байгууллага буюу 8.5 хувь нь “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 1 байгууллага буюу 1 хувь нь “Дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт, авсан бол 12 байгууллага буюу 11.3 хувь нь түүвэрт хамрагдаж, 7 байгууллага буюу 6.6 хувьд нь итгэл үзүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.9.1 Салбарын хэмжээнд батлагдсан төсвийг нийт дүнгээр хэмнэсэн боловч гэрэл, цахилгааны зардлыг 281.4 сая, байрны түрээсийн зардлыг 11.8 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 217.9 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг баримталж ажиллах талаар зөвлөмж өгөх

2.9.2 Салбарын хэмжээнд авлагын өмнөх оны эцсийн үлдэгдэл 147,190.7 сая төгрөг байсан бол 2016 оны эцэст 174,103.9 сая төгрөг болж 26,913.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг баримталж ажиллах талаар зөвлөмж өгөх

2.9.3 Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 2016 оны батлагдсан төсөв, орон тоо нь хэтрээгүй боловч тус сангийн харьяа 21 хүрээлэнгийн хэмжээнд тэтгэвэрт гарсан 74 ажилтанд үндсэн цалин, докторын болон зэрэг дэвийн нэмэгдэлд 951.3 сая төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг баримталж ажиллах, төсөв, орон тоог хэмнэх, гэрээгээр ажиллуулах арга хэмжээ авах талаар зөвлөмж өгөх

2.9.4 Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуулиар 4,749.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 4,670.7 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 79.0 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн заалтыг хэрэгжүүлж, орлогын төлөвлөгөөг биелүүлж, ажиллах талаар зөвлөмж өгөх

2.9.5 Салбарын 2016 оны төсөл, арга хэмжээний зардлын төсөвт нийт 3,290.9 сая төгрөг батлагдсан бөгөөд үүний дотор музейн үзвэр авах зардалд 288.7 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 284.0 сая төгрөгийн үнэтэй /36.0 сая төгрөгийн үнэтэй Түрэгийн үеийн зоос 200 ш, Юань гүрний үеийн цаасан мөнгө 1ш/ музейн үзмэрийг БСШУЯ-ны /хуучин нэрээр/ ТНБД-ын 2016 оны А/378,А/367 дугаар тушаалаар Үнэлгээний хороо, Ажлын хэсэг байгуулан, нэр бүхий 2 иргэнтэй шууд гэрээ байгуулан худалдан авсан нь ТБОНӨХБАҮХАТХ, БСШУС-ын 2015 оны А/335 дугаар тушаалаар батлагдсан "Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тогтоох мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам"-ын 1.1-д "Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тогтоох мэргэжлийн зөвлөлийн ажиллах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна", 9.2-т "Зөвлөлийн хурал нь нийт 10 буюу түүнээс дээш гишүүд ороцсоноор хүчин төгөлдөр болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Холбогдох эрх зүйн актыг боловсронгуй болгох талаар зөвлөмж өгөх

2.9.6 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 19,673.3 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрч, Архангай, Хэнтий аймгийн Боловсролын газар, Завхан аймгийн Хөгжим бүжгийн коллеж, Биеийн тамир, спортын газар, Үндэсний номын сан, Театрын музей, ШУТИС, ШУТС, Булган Хангал спортын бэлтгэлийн төв зэрэг 9 байгууллага “Хязгаарлалттай” санал дүгнэлт, Баян-Өлгий аймгийн Боловсролын газар “Санал, дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт авсан байна.

Шийдвэрлэсэн: Дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулж, хязгаарлалттай болон санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлт авсан байгууллагуудын холбогдох албан тушаалтанд арга хэмжээ авах талаар зөвлөмж өгөх

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Аудитын явцад Сангийн яамны Төрийн сангаас ирүүлсэн ТЕЗ болон Сангийн яам хооронд тооцоо нийлсэн баримт нь зөвхөн урсгал санхүүжилтийн гүйлгээг агуулсан байна. Мөн Төрийн сангийн төсвийн хэлбэлзлийн тайлан эцэслэгдээгүй, нэгтгэлийн Э-тайлан програмаас хэвлэгдэж буй санхүүгийн байдлын тайланд Засгийн газрын хувь оролцооны дүн дутуу татагдаж байгаа нь ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг ЗГСНТ-д нэгтгүүлэхэд зарим тоон мэдээлэл өөрчлөгдөх эрсдэлтэй байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Аудитын явцад гүйцэтгэсэн горим, сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг нэгтгэх, тайлагнах үйл явц, Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа бодлого, шийдвэртэй нийцэж байгаа эсэхийг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад 2016 онд хийсэн аудитаар нийт 19,673.3 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрсэн ба 29.7 сая төгрөгийн төлбөрийг барагдуулах акт тогтоож, 89.1 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч, 19,554.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, аудитын явцад 797.4 сая төгрөгийн зөрчлийг залруулав.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 4 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Материаллаг байдлын түвшинг 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд толилуулсан нийт зардлын 2.0 хувиар тооцож 27.923.1 сая төгрөгөөр тогтоов

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим чиглэгдсэн.

Энэ нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны төсвийн ерөнхий нягтлан бодогч болон холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 Зардал

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Салбарын хэмжээнд батлагдсан төсвийг нийт дүнгээр хэмнэсэн боловч гэрэл, цахилгааны зардлыг 281.4 сая, байрны түрээсийн зардлыг 11.8 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 217.9 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т албан бичгээр ирүүлэх

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг буурах, төсөв хэтрүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 Авлага

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Салбарын хэмжээнд авлагын өнгөрсөн оны эцсийн үлдэгдэл 147,190.7 сая төгрөг байсан бол 2016 оны эцэст 174,103.9 сая төгрөг болж 26,913.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Авлага үүсгэхгүй ажиллаж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг баримтлах, зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т албан бичгээр ирүүлэх

Эрсдэлүүд

Төсвийн авлага нэмэгдэх, төсвийн үр ашиг буурах, холбогдох хуулийн заалт зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.3 Цалин

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 2016 оны батлагдсан төсөв, орон тоо нь хэтрээгүй боловч тус сангийн харьяа 21 хүрээлэнгийн хэмжээнд тэтгэвэрт гарсан 74 ажилтанд үндсэн цалин, докторын болон зэрэг дэвийн нэмэгдэлд 951.3 сая төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг баримталж ажиллах, төсөв, орон тоог хэмнэх, гэрээгээр ажиллуулах арга хэмжээ авах, зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т албан бичгээр ирүүлэх

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг буурах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил, дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.4 Төсвийн орлого

Тэргүүлэх ач холбогдол №4

ҮАГ-ын ажиглалт

Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуулиар 4,749.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 4,670.7 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 79.0 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн заалтыг хэрэгжүүлж, орлогыг биелүүлж ажиллах, зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т албан бичгээр ирүүлэх

Эрсдэлүүд

Улсын төсвийн орлого тасалдах, холбогдох хуулийн заалт зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.5 Худалдан авалт

Тэргүүлэх ач холбогдол №5

ҮАГ-ын ажиглалт

Салбарын 2016 оны төсөл, арга хэмжээний зардлын төсөвт 3,290.9 сая төгрөг батлагдсан бөгөөд үүний дотор музейн үзвэр авах зардалд 288.7 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 284.0 сая төгрөгийн үнэтэй /36.0 сая төгрөгийн үнэтэй Түрэгийн үеийн зоос 200 ш, Юань гүрний үеийн цаасан мөнгө 1ш/ музейн үзмэрийг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

ҮАГ-ын зөвлөмж

Холбогдох эрх зүйн актыг боловсронгуй болгох талаар арга хэмжээ авах, ТБОНӨХБАҮХАТХ-г хэрэгжүүлж ажиллах, зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т албан бичгээр ирүүлэх

Эрсдэлүүд

Улсын төсвийн орлого тасалдах, холбогдох хуулийн заалт зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.6 Дотоод хяналт

Тэргүүлэх ач холбогдол №6

ҮАГ-ын ажиглалт

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын харьяа байгууллагуудын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 19.673.3 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрч, Архангай, Хэнтий аймгийн Боловсролын газар, Завхан аймгийн Хөгжим бүжгийн коллеж, Биеийн тамир, спортын газар, Үндэсний номын сан, Театрын музей, ШУТИС, ШУТС, Булган Хангал спортын бэлтгэлийн төв зэрэг 9 байгууллага “Хязгаарлалттай” санал дүгнэлт, Баян-Өлгий аймгийн Боловсролын газар “Санал, дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт авсан байна.

ҮАГ-ын зөвлөмж

Дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулж, хязгаарлалттай болон санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлт авсан байгууллагуудын холбогдох албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д заасны дагуу арга хэмжээ авах, зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т албан бичгээр ирүүлэх

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, холбогдох хуулийн заалт зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/мян.төг /	
		2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		317,301,478.7	404,725,060.2
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	97,131,002.1	112,643,329.6
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4бa, 4б	-	8,000,000.0
АВЛАГА	5а, 5б, 6а,	147,190,677.2	174,103,986.9
УРЬДЧИЛГАА	7а, 7б	1,998,939.3	1,909,184.4
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	70,787,499.0	20,174,566.4
НӨӨЦИЙН БАРАА	9а	193,361.0	-
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		-	87,893,992.9
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад		-	87,893,992.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		369,984,544.5	529,314,293.9
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б,	369,984,544.5	529,314,293.9
Биет хөрөнгө		365,885,862.1	406,562,392.0
Биет бус хөрөнгө	13	4,098,682.4	122,751,901.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		687,286,023.2	934,039,354.0
НИЙТ ӨР ТӨЛБӨР		47,890,183.4	40,424,484.4
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	45,677,417.3	32,805,396.5
Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	17,847,926.9	-
Өглөг	17а, 17б	6,143,278.9	11,276,183.0
Урьдчилж орсон орлого	18а, 18б	21,686,211.5	21,529,213.5
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19	2,212,766.1	7,619,087.9
Урт хугацаат зээл	20а, 20б	2,212,766.1	7,619,087.9
Төгрөг		72,031.9	70,031.9
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		639,395,839.8	893,614,869.6
Засгийн газрын хувь оролцоо		639,395,839.8	893,614,869.6
Хуримтлагдсан үр дүн		297,536,782.6	516,654,849.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		165,546,449.5	167,740,101.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		687,286,023.2	934,039,354.0

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/мян.төг /	
		2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		460,932,926.1	1,505,113,936.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а,1б	211,740,709.3	213,300,173.3
Нийтлэг татварын бус орлого		204,838,504.9	205,163,013.7
Тусламжийн орлого		272,109.1	7,412,668.1
Улсын төсөв ОНТөсөв хоорондын шилжүүлэг		6,630,095.3	724,491.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		249,192,216.8	1,291,813,763.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	380,642,981.0	1,396,157,840.6
УРСГАЛ ЗАРДАЛ		315,332,698.5	1,385,429,185.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		268,040,853.2	383,144,111.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		143,092,013.3	150,119,395.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		15,804,667.9	16,049,687.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		11,830,116.6	10,995,929.0
Хангамж, бараа материалын зардал		8,261,587.9	105,696,703.0
Нормативт зардал		768,845.5	1,579,698.7
Эд хогшил, урсгал засварын зардал		4,710,071.2	4,061,898.2
Томилолт, зочны зардал		4,988,093.4	3,203,417.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төл бөр, хураамж		29,005,377.9	38,139,874.4
Бараа үйлчилгээний бусад зардал		49,580,079.4	53,297,509.3
ХҮҮ		58,375.2	135,692.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		47,233,470.1	1,002,149,380.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		65,310,282.5	10,728,655.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		80,289,945.1	108,956,095.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		687,562.5	4,008,809.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		21,478,236.0	2,775,290.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		59,499,271.6	110,189,615.1

4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг /

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/ өмч
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	520,370,836.0	520,370,836.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	18,426,832.1	18,426,832.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	538,797,668.0	538,797,668.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	40,375,209.7	40,375,209.7
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	723,690.5	723,690.5
Тайлант үеийн үр дүн	59,499,271.6	59,499,271.6
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	639,395,839.8	639,395,839.8
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	639,395,839.8	639,395,839.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	143,741,388.4	143,741,388.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	783,137,228.2	783,137,228.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	228,026.3	228,026.3
Тайлант үеийн үр дүн	110,189,615.1	110,189,615.1

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг /

Тайлангийн үзүүлэлт	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,247,996,813.3	1,521,953,550.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	213,321,578.6	229,937,548.4
Нийтлэг татварын бус орлого	203,535,019.0	220,422,927.3
Тусламжийн орлого	-	8,790,129.5
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	9,786,559.6	724,491.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,034,675,234.7	1,292,016,002.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,093,597,884.4	1,274,335,407.6
УРСГАЛ ЗАРДАЛ	1,093,597,884.4	1,274,335,407.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	256,375,278.1	270,274,886.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	145,258,840.9	150,693,441.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,276,148.6	16,781,688.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,372,457.1	11,777,644.9
Хангамж, бараа материалын зардал	8,313,861.3	7,797,300.7
Нормативт зардал	863,160.2	1,790,883.5
Эд хогшил, урсгал засварын зардал	4,406,309.1	5,400,186.0
Томилолт, зочны зардал	5,061,536.8	3,001,758.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,264,573.6	37,729,839.3
Бараа үйлчилгээний бусад зардал	32,558,390.6	35,302,143.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	837,222,606.3	1,004,060,520.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	154,398,928.9	247,618,142.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	150.0	11,318.2
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	118,926,093.5	201,215,682.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	118,926,093.5	201,215,682.3
Дотоод эх үүсвэрээр	118,926,093.5	201,215,682.3

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(118,925,943.5)	(201,204,364.1)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(34,744,461.5)	(30,901,451.2)
Бусад эх үүсвэр	55,270.0	1,190,245.4
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН Ц ЭВЭР ЗЭЭЛ	34,963,984.1	30,981,996.9
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДА Л	(164,252.6)	1,109,699.7
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	728,523.9	15,512,327.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлд эгдэл	96,402,478.3	97,131,002.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үл дэгдэл	97,131,002.1	112,643,329.6

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,338,660,482.2	1,253,300,288.3	85,360,193.9	93.6
УРСГАЛ ЗАРДАЛ	1,055,990,571.5	1,042,048,375.5	13,942,196.0	98.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,181,813.2	104,678,808.7	3,503,004.5	96.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,929,686.3	45,429,903.8	1,499,782.5	96.8
Үндсэн цалин	40,836,366.1	40,441,458.4	394,907.7	99.0
Нэмэгдэл	2,371,395.6	1,858,645.9	512,749.7	78.4
Унаа хоолны хөнгөлөлт	1,648,080.7	1,463,897.0	184,183.7	88.8
Урамшуулал	515,117.1	398,509.6	116,607.5	77.4
Гэрээт ажлын хөлс	1,558,726.8	1,267,393.0	291,333.8	81.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,147,471.1	4,919,749.5	227,721.6	95.6
Тэтгэврийн даатгал	3,227,146.6	3,267,891.0	-40,744.4	101.3
Тэтгэмжийн даатгал	387,009.7	331,147.8	55,861.9	85.6
ҮОМШӨ-ний даатгал	463,035.9	422,392.6	40,643.3	91.2
Ажилгүйдлийн даатгал	94,725.3	100,545.2	-5,819.9	106.1
Эрүүл мэндийн даатгал	975,553.6	797,772.8	177,780.8	81.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,148,767.9	9,686,384.0	462,383.9	95.4
Гэрэл, цахилгаан	2,720,573.1	3,001,935.9	-281,362.8	110.3
Түлш, халаалт	5,194,674.3	4,766,166.1	428,508.2	91.8
Цэвэр, бохир ус	1,259,545.8	932,439.1	327,106.7	74.0
Байрны түрээс	973,974.7	985,842.8	-11,868.1	101.2
Хангамж, бараа материалын зардал	3,383,943.8	3,286,013.2	97,930.6	97.1
Бичиг хэрэг	173,274.7	170,609.7	2,665.0	98.5
Тээвэр, шатахуун	227,655.8	217,295.6	10,360.2	95.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	288,658.9	295,677.5	-7,018.6	102.4
Ном, хэвлэл	1,917,767.6	1,822,431.3	95,336.3	95.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,959.8	29,324.3	1,635.5	94.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	745,627.0	750,674.8	-5,047.8	100.7

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нормативт зардал	714,971.0	705,914.8	9,056.2	98.7
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	465.0	314.9	150.1	67.7
Хоол, хүнс	124,665.8	120,723.0	3,942.8	96.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	589,840.2	584,876.9	4,963.3	99.2
Эд хогшил, урсгал засварын зардал	716,320.1	613,969.1	102,351.0	85.7
Багаж, техник, хэрэгсэл	316,557.7	318,204.6	-1,646.9	100.5
Тавилга	14,000.0	0.0	14,000.0	0.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,861.9	2,668.6	5,193.4	33.9
Урсгал засвар	377,900.5	293,096.0	84,804.5	77.6
Томилолт, зочны зардал	569,265.8	513,794.1	55,471.7	90.3
Гадаад албан томилолт	0.0	24,043.1	-24,043.1	0.0
Дотоод албан томилолт	569,265.8	489,751.0	79,514.8	86.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээн ий төлбөр, хураамж	33,047,904.1	31,783,279.6	1,264,624.5	96.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг аж ил үйлчилгээний төлбөр хураамж	32,493,763.0	31,286,945.5	1,206,817.5	96.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	89,331.7	81,141.5	8,190.2	90.8
Даатгалын үйлчилгээ	36,345.6	34,038.1	2,307.5	93.7
Тээврийн хэрэгслийн татвар	15,608.8	11,225.4	4,383.4	71.9
Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,299.6	1,107.5	1,192.1	48.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	168,188.8	163,676.5	4,512.3	97.3
Газрын төлбөр	55,343.0	49,884.8	5,458.2	90.1
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгэ эний хураамж	1,028.3	293.3	735.0	28.5
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	185,995.3	154,966.9	31,028.4	83.3
Бараа үйлчилгээний бусад зардал	7,523,483.1	7,739,800.6	-216,317.5	102.9
Бараа үйлчилгээний бусад зардал	5,636,296.3	5,928,762.4	-292,466.1	105.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,887,186.8	1,811,038.2	76,148.6	96.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	947,808,758.3	937,369,566.7	10,439,191.6	98.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	886,432,480.5	876,399,164.2	10,033,316.3	98.9
Засгийн газрын дотоод шилжүүлэг	886,390,414.3	876,368,205.3	10,022,209.0	98.9
Засгийн газрын гадаад шилжүүлэг	42,066.2	30,958.9	11,107.3	73.6
Бусад урсгал шилжүүлэг	61,376,277.8	60,970,402.6	405,875.2	99.3
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	298,039.6	281,524.2	16,515.4	94.5
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,995,508.1	59,785,038.7	210,469.4	99.7

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,050,205.1	871,314.7	178,890.4	83.0
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,525.0	32,525.0	0.0	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	191,841,710.7	180,188,409.7	11,653,301.0	93.9
Барилга байгууламж	148,852,377.7	130,250,029.6	18,602,348.1	87.5
Их засвар	8,828,194.6	7,910,508.9	917,685.7	89.6
Тоног төхөөрөмж	19,182,468.0	23,738,178.7	-4,555,710.7	123.8
Бусад хөрөнгө	14,978,670.4	18,289,692.6	-3,311,022.2	122.1
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	90,828,200.0	31,063,503.1	59,764,696.9	34.2
Эргэж төлөгдөх зээл	90,828,200.0	31,063,503.1	59,764,696.9	34.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,338,660,482.2	1,249,213,246.4	89,447,235.8	93.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,301,042,279.9	1,209,926,614.1	91,115,665.8	93.0
Улсын төсвөөс санхүүжих	1,301,042,279.9	1,209,926,614.1	91,115,665.8	93.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛ АГААНААС	29,695,614.1	30,651,825.3	-956,211.2	103.2
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,303,686.6	4,242,199.7	61,486.9	98.6
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	446,014.3	428,467.7	17,546.6	96.1
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	0.0	0.0	0.0	0.0
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	24,945,913.2	25,981,157.9	-1,035,244.7	104.2
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	7,922,588.2	8,634,806.9	-712,218.7	109.0
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	7,922,588.2	8,634,806.9	-712,218.7	109.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	8,846,367.4	-8,846,367.4	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	6,406,927.3	-6,406,927.3	0.0
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	89,989.0	94,386.0	-4,397.0	104.9
БАЙГУУЛЛАГЫН ТОО	87.0	87.0	0.0	100.0
Төсвийн байгууллага	87.0	87.0	0.0	100.0
Төсвөөс гадуур байгууллага	0.0	0.0	0.0	0.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	4,397.0	4,453.0	-56.0	101.3
Удирдах ажилтан	171.0	177.0	-6.0	103.5
Гүйцэтгэх ажилтан	3,480.0	3,487.0	-7.0	100.2

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үйлчлэх ажилтан	718.0	761.0	-43.0	106.0
Гэрээт ажилтан	28.0	28.0	0.0	100.0
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНД ЖААР)	81,108.0	85,393.0	-4,285.0	105.3
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	76,324.0	79,711.0	-3,387.0	104.4
Төрийн өмчит ЕБС	76,324.0	79,711.0	-3,387.0	104.4
Хувийн ЕБС	0.0	0.0	0.0	0.0
СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	4,364	5,222	-858	119.7
Төрийн өмчит СӨБ байгууллага	4,364	5,222	-858	119.7
Хувийн өмчит СӨБ байгууллага	0	0	0	0.0
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	420	460	-40	109.5
Төрийн өмчит МСҮТ	420	460	-40	109.5
Хувийн МСҮТ	0	0	0	0.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	4,397	4,453	-56	101.3
Төрийн захиргааны албан хаагч	528	546	-18	103.4
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	2	7	-5	350.0
СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	171	174	-3	101.8
ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	1,566	1,544	22	98.6
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	981	970	11	98.9
Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМ)	268	250	18	93.3
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч	42	7	35	16.7
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	839	955	-116	113.8
Гэрээт ажилтан	0	0	0	0.0
Улс төрийн албан хаагч (УТ)	0	0	0	0.0